

ТҮШИГ-УУЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙ
хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

2026.04.27

Дархан хот

Ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 27-нд Дархан Уул аймаг Дархан сум 3-р баг өөрийн байранд болов.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэв.

Хуралд :

1. Ж.Баяраа /рд: ТЖ62062018/ 830800 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 19,1 %
2. Ж.Батсайхан /рд: ТВ71041516/ 869120 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20,0 %
3. Ж.Баянтөр /рд: ТВ64012611/ 869050 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 20,0 %

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2568970 ширхэг хувьцаа эзэмшдэг 3 хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр хуралд оролцохоор ирсэнг бүртгэв.

Хурлын дарга Ж.Батсайхан: за өнөөдөр хуралд ирсэн та нарт энэ өдрийн мэндийг хүргэе. Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулна. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн тул хурлаа эхлэе.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа ирц танилцуулан тооллогын комиссын тогтоол танилцуулав.

Нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 59,1 хувь болж байгааг Хурлын даргад мэдээлж хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компаний тухай хуулийн 69,1 дэх хэсгийг үндэслэн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцон ,тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дарга: Ж.Батсайхан

Хурлаар хэлэлцэх асуудал бол 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах мөн цаашдын үйл ажиллагааны талаар хэлэлцэнэ.

2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав /тайланг хавсаргав/

Тайлантай холбоотой санал асуулга:

Ж.Баянтөр: 2025 оны үйл ажиллагааны тайланг сонслоо. Манай үйлдвэрийн засвар үйлчилгээ гар ажиллагаа ихтэй, хүний нөөц дутмаг мөн төмөр замын засвар арчлалт , сум дэр модны үнэ зах зээлд өндөр байгаа нь жил бүр ажиглагдаж байна. Ингээд 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлтийг батлахыг дэмжиж байна.

Ж.Баяраа: Манай компани өнгөрсөн онд БНХАУ-аас орчин үеийн элс, хайрга сорох насосыг захиалан авчирч, үйлдвэрлэлд амжилттай нэвтрүүлсэн. Энэхүү хөрөнгө оруулалтын үр дүнд 2026 онд бүтээгдэхүүний гарц мэдэгдэхүйц өсөж, засвар үйлчилгээний зардал буурч, үйл ажиллагааны бүтээмж нэмэгдэн, компанийн ашигт ажиллагаа сайжрах бодит боломж бүрдэж байна.

Ж.Батсайхан : Захиалсан насос тоног төхөөрөмжийг хүлээн авсны дараа угсралт, суурилуулалт, ашиглалтад оруулах ажлыг манай хамт олон өөрсдийн хүч, нөөц боломжоо бүрэн дайчлан амжилттай гүйцэтгэсэн. Энэ нь ажилтнуудын идэвх санаачлага, ур чадвар, хариуцлагатай байдлын бодит илрэл болж, компанийн үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулсан.

Санал асуулга дууссан бол санал авах хуудсаар зөвшөөрсөн татгалзсан саналын тоогоор саналаа хураая.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэтуяа: Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн санал нь компаний тухай хуулийн 63 дугаар зүйлд заасан хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хувьд хүрсэн тухай, хурлын шийдвэрийг батлах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Зөвшөөрсөн 2568970 ширхэг хувьцаа буюу 59,1 хувиар батлав.

Ж.Батсайхан тогтоолыг танилцуулав .

1. Тогтоол -1 . “ Түшиг-Уул “ ХК-ны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг талаарх ТУЗ-ын дүгнэлтийг баталсугай.

Хурлын дарга Ж.Батсайхан хэлэлцэх асуудал дууссан хурлыг дуусгав.

 ХУРЛЫН ДАРГА...../Ж.БАТСАЙХАН/